



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Акт тогтоох	19
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/94-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	129,094,516.85	150,388,391.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	129,094,516.85	150,388,391.85
35400	Хангамжийн материал	129,094,516.85	150,388,391.85
35410	Бичиг хэргийн материал	787,900.00	864,800.00
35420	Аж ахуйн материал	88,142,335.72	92,413,090.72
35450	Барилгын засварын материал	569,040.00	261,000.00
35460	Хүнсний материал	0.00	5,355,060.00
35470	Бусад хангамжийн материал	39,595,241.13	51,494,441.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,978,159,117.89	1,934,573,914.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,978,159,117.89	1,934,573,914.48
39200	Биет хөрөнгө	1,735,857,117.89	1,685,341,914.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,643,756,759.84	1,643,756,759.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(93,261,689.28)	(139,892,533.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,063,500.00	21,063,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,964,099.95)	(18,138,050.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	223,478,820.64	195,006,416.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(141,569,075.74)	(120,299,858.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	118,213,984.76	81,948,116.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(81,445,930.41)	(29,126,619.64)
39209	Зам, гүүрийн байгууламж	7,952,316.32	7,952,316.32
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,123,924.78)	(1,736,974.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,912,146.16	53,579,495.97
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,442,311.17)	(14,512,064.17)
39217	Ном	3,286,621.50	5,741,411.01
39300	Биет бус хөрөнгө	242,302,000.00	249,232,000.00
39301	Програм хангамж	880,000.00	7,810,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000.00)	(880,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	242,302,000.00	242,302,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,107,253,634.74	2,084,962,306.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	450,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	450,000.00
41300	Өглөг	0.00	450,000.00
41360	Бусад өглөг	0.00	450,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	450,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,107,253,634.74	2,084,512,306.33
51	Засгийн газрын хувь оролцоо	2,107,253,634.74	2,084,512,306.33
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,487,967,337.20	1,487,967,337.20
51200	Хуримтлагдсан үр дүн	(763,637,876.32)	(813,704,204.73)
51210	Өмнөх үеийн үр дүн	(719,945,328.27)	(763,637,876.32)
51220	Тайлант үеийн үр дүн	(43,692,548.05)	(50,066,328.41)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,382,924,173.86	1,410,249,173.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,107,253,634.74	2,084,962,306.33

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,293,931,346.29	1,304,806,721.51
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,198,746.29	19,711,944.51
120	Нийтлэг татварын бус орлого	23,198,746.29	19,711,944.51
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	16,645,633.50	7,452,709.51
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,553,112.79	12,259,235.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,270,732,600.00	1,285,094,777.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,136,353,800.00	1,124,529,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,136,353,800.00	1,124,529,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,493,100.00	15,458,479.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,833,029.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,493,100.00	4,625,450.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	129,885,700.00	145,107,298.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	129,885,700.00	145,107,298.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,337,623,894.34	1,341,742,935.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,337,623,894.34	1,341,742,935.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,211,589,546.34	1,288,798,819.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	835,312,138.41	870,320,332.00
210101	Үндсэн цалин	571,262,851.41	614,437,208.00
210102	Нэмэгдэл	198,388,126.00	204,989,531.00
210104	Урамшуулал	62,710,252.00	50,893,593.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,950,909.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,771,212.59	112,044,883.00
210201	Тэтгэврийн даатгал	76,314,183.06	80,900,813.16
210202	Тэтгэмжийн даатгал	7,383,399.11	7,971,328.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,906,719.29	6,377,062.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,378,670.69	1,526,789.07
210205	Эрүүл мэндийн даатгал	13,788,240.44	15,268,890.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,621,081.00	137,648,698.00
210301	Гэрэл, цахилгаан	9,152,076.00	10,122,746.00
210302	Түлш, халаалт	103,001,817.00	105,767,918.00
210303	Цэвэр, бохир ус	14,467,188.00	21,758,034.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,465,228.35	7,309,791.00
210401	Бичиг хэрэг	1,085,000.00	442,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,882,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	581,100.00	800,000.00
210404	Ном, хэвлэл	1,012,056.35	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,288,250.00	2,722,491.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,444,254.00	1,462,300.00
210408	Бараа материал акталсны зардал	7,554,568.00	0.00
2105	Нормативт зардал	19,789,095.00	29,572,740.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	201,100.00	321,000.00

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	19,587,995.00	28,727,540.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	524,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,913,760.00	14,164,640.00
210602	Тавилга	0.00	20,400.00
210604	Урсгал засвар	9,913,760.00	14,144,240.00
2107	Томилолт, зочны зардал	418,300.00	401,800.00
210702	Дотоод албан томилолт	418,300.00	401,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,042,300.00	14,421,748.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,072,300.00	13,269,748.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,152,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,256,430.99	102,914,187.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	292,000.00	235,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,353,700.00	3,528,389.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,610,730.99	99,150,798.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,034,348.00	52,944,116.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,255,440.00	41,077,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,455,440.00	40,583,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	494,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	108,778,908.00	11,866,916.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(43,692,548.05)	(36,936,214.21)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	13,130,114.20
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	13,130,114.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(43,692,548.05)	(50,066,328.41)
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,270,732,600.00	1,285,094,777.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,270,732,600.00	1,285,094,777.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,136,353,800.00	1,124,529,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,136,353,800.00	1,124,529,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,493,100.00	15,458,479.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,833,029.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,493,100.00	4,625,450.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	129,885,700.00	145,107,298.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	129,885,700.00	145,107,298.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,247,176,300.00	1,251,176,777.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,247,176,300.00	1,251,176,777.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,122,288,342.00	1,198,232,661.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	831,198,398.00	870,320,328.00
210101	Үндсэн цалин	512,591,109.00	627,727,868.00
210102	Нэмэгдэл	252,946,137.00	191,778,899.00
210104	Урамшуулал	62,710,252.00	50,813,561.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,950,900.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,369,394.00	112,044,885.00
210201	Тэтгэврийн даатгал	67,995,121.00	78,133,677.86
210202	Тэтгэмжийн даатгал	8,740,600.00	8,676,780.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,992,500.00	6,941,424.14
210204	Ажилгүйдлийн даатгал	4,663,453.00	1,663,000.26
210205	Эрүүл мэндийн даатгал	14,977,720.00	16,630,002.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	129,217,000.00	137,648,698.00
210301	Гэрэл, цахилгаан	11,747,995.00	10,122,746.00
210302	Түлш, халаалт	103,001,817.00	105,767,918.00
210303	Цэвэр, бохир ус	14,467,188.00	21,758,034.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,601,200.00	8,531,900.00
210401	Бичиг хэрэг	618,900.00	594,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,358,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	581,100.00	800,000.00
210404	Ном, хэвлэл	63,400.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,704,100.00	1,661,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,133,700.00	4,117,400.00
2105	Нормативт зардал	19,058,150.00	35,939,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	402,300.00	344,400.00
210502	Хоол, хүнс	16,920,850.00	33,632,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,735,000.00	1,962,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,664,000.00	13,242,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	370,700.00	0.00
210602	Тавилга	0.00	779,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	9,293,300.00	12,462,300.00

2107	Томилолт, зочны зардал	418,300.00	401,800.00
210702	Дотоод албан томилолт	418,300.00	401,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,042,300.00	15,916,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,072,300.00	14,764,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,152,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,719,600.00	4,186,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,919,600.00	4,186,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,887,958.00	52,944,116.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,109,050.00	41,077,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,309,050.00	40,583,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	494,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	108,778,908.00	11,866,916.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	108,778,908.00	11,847,716.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	23,556,300.00	33,918,000.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	23,556,300.00	33,918,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,556,300.00	33,918,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,556,300.00	33,918,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,556,300.00	33,918,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(23,556,300.00)	(33,918,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,487,967,337.20	1,382,924,173.86	(719,945,328.27)	2,150,946,182.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,487,967,337.20	1,382,924,173.86	(719,945,328.27)	2,150,946,182.79
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчилөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			(43,692,548.05)	(43,692,548.05)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,487,967,337.20	1,382,924,173.86	(763,637,876.32)	2,107,253,634.74
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,487,967,337.20	1,382,924,173.86	(763,637,876.32)	2,107,253,634.74
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,487,967,337.20	1,382,924,173.86	(763,637,876.32)	2,107,253,634.74
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		27,325,000.00		27,325,000.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчилөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			(50,066,328.41)	(50,066,328.41)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,487,967,337.20	1,410,249,173.86	(813,704,204.73)	2,084,512,306.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,277,542,900.00	1,269,636,298.00	7,906,602.00	99.38%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,277,542,900.00	1,238,288,098.00	39,254,802.00	96.93%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,236,459,700.00	1,185,363,182.00	51,096,518.00	95.87%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	874,310,400.00	869,184,391.00	5,126,009.00	99.41%
210101	Үндсэн цалин	580,903,700.00	627,727,868.00	-46,824,168.00	108.06%
210102	Нэмэгдэл	247,295,400.00	190,642,962.00	56,652,438.00	77.09%
210104	Урамшуулал	46,111,300.00	50,813,561.00	-4,702,261.00	110.20%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,618,400.00	111,902,893.00	4,715,507.00	95.96%
210201	Тэтгэврийн даатгал	81,126,000.00	77,991,685.86	3,134,314.14	96.14%
210202	Тэтгэмжийн даатгал	8,873,100.00	8,676,780.20	196,319.80	97.79%
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,098,500.00	6,941,424.14	157,075.86	97.79%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,774,600.00	1,663,000.26	111,599.74	93.71%
210205	Эрүүл мэндийн даатгал	17,746,200.00	16,630,002.54	1,116,197.46	93.71%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,555,300.00	137,648,698.00	7,906,602.00	94.57%
210301	Гэрэл, цахилгаан	11,141,400.00	10,122,746.00	1,018,654.00	90.86%
210302	Түлш, халаалт	113,863,900.00	105,767,918.00	8,095,982.00	92.89%
210303	Цэвэр, бохир ус	20,550,000.00	21,758,034.00	-1,208,034.00	105.88%
2104	Хангамж, бараа материалын зардал	9,089,200.00	8,150,900.00	938,300.00	89.68%
210401	Бичиг хэрэг	594,500.00	594,500.00	0.00	100.00%
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	0.00	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,358,200.00	1,358,200.00	0.00	100.00%
210404	Ном, хэвлэл	938,300.00		938,300.00	0.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,280,800.00	1,280,800.00	0.00	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,117,400.00	4,117,400.00	0.00	100.00%
2105	Нормативт зардал	37,939,600.00	35,939,600.00	2,000,000.00	94.73%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	344,400.00	344,400.00	0.00	100.00%
210502	Хоол, хүнс	35,632,600.00	33,632,600.00	2,000,000.00	94.39%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,962,600.00	1,962,600.00	0.00	100.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,709,200.00	12,299,100.00	30,410,100.00	28.80%
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,989,900.00		19,989,900.00	0.00%
210602	Тавилга	11,200,000.00	779,800.00	10,420,200.00	6.96%
210604	Урсгал засвар	11,519,300.00	11,519,300.00	0.00	100.00%
2107	Томилолт, зочны зардал	401,800.00	401,800.00	0.00	100.00%
210702	Дотоод албан томилолт	401,800.00	401,800.00	0.00	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,068,900.00	6,068,900.00	0.00	100.00%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,916,900.00	4,916,900.00	0.00	100.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	0.00	100.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,766,900.00	3,766,900.00	0.00	100.00%

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,766,900.00	3,766,900.00	0.00	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,083,200.00	41,077,200.00	6,000.00	99.99%
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,083,200.00	41,077,200.00	6,000.00	99.99%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,583,200.00	40,583,200.00	0.00	100.00%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	494,000.00	6,000.00	98.80%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		11,847,716.00		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,847,716.00		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		31,348,200.00	-31,348,200.00	
	Дотоод эх үүсвэрээр		31,348,200.00	-31,348,200.00	
223001	Бусад хөрөнгө		31,348,200.00	-31,348,200.00	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,277,542,900.00	1,269,636,298.00	7,906,602.00	99.38%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,124,529,000.00	1,124,529,000.00	0.00	100.00%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,124,529,000.00	1,124,529,000.00	0.00	100.00%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	153,013,900.00	145,107,298.00	7,906,602.00	94.83%
320001	Орон нутгийн төсвөөс	153,013,900.00	145,107,298.00	7,906,602.00	94.83%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	954.00	934.00	20.00	97.90%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	66.00	65.00	1.00	98.48%
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	0.00	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	44.00	43.00	1.00	97.73%
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00	0.00	100.00%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	821.00	801.00	20.00	97.56%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	821.00	801.00	20.00	97.56%
630001	Төрийн өмчит ЕБС	821.00	801.00	20.00	97.56%
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	45.00	45.00	0.00	100.00%
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00	0.00	100.00%
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	0.00	100.00%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	19.00	0.00	100.00%

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		15,458,479.00	(15,458,479.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		15,458,479.00	(15,458,479.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		15,458,479.00	(15,458,479.00)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,135,937.00	(1,135,937.00)
210101	Үндсэн цалин		1,135,937.00	(1,135,937.00)
210102	Нэмэгдэл			
210103	Унаа хоолны хөнгөлөлт			
210104	Урамшуулал			
210105	Гэрээт ажлын хөлс			
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		141,992.00	(141,992.00)
210201	Тэтгэврийн даатгал		141,992.00	(141,992.00)
210202	Тэтгэмжийн даатгал			
210203	ҮОМШӨ-ний даатгал			
210204	Ажилгүйдлийн даатгал			
210205	Эрүүл мэндийн даатгал			
2104	Хангамж, бараа материалын зардал		381,000.00	(381,000.00)
210401	Бичиг хэрэг			
210402	Тээвэр, шатахуун			
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			
210404	Ном, хэвлэл			
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		381,000.00	(381,000.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		943,000.00	(943,000.00)
210601	Багаж, техник, хэрэгсэл			
210602	Тавилга			
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			
210604	Урсгал засвар		943,000.00	(943,000.00)
2107	Томилолт, зочны зардал			
210701	Гадаад албан томилолт			
210702	Дотоод албан томилолт			
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		12,417,350.00	(12,417,350.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		12,417,350.00	(12,417,350.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		420,000.00	(420,000.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		420,000.00	(420,000.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		19,200.00	(19,200.00)
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		19,200.00	(19,200.00)
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		19,200.00	(19,200.00)
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		15,458,479.00	(15,458,479.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		15,458,479.00	(15,458,479.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,833,029.00	(10,833,029.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,625,450.00	(4,625,450.00)

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн *Ицаашид Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль гэх* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Б.Батцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь *“Хүүхдэд ээлтэй, бүгдэд нээлттэй, суралцагч байгууллага болно. Багаар ажиллаж, хамтдаа хөгжье”* гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,337,623.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,376.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,363.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,291.3 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			

Бараа материал	129,094.5	150,388.4	21,293.9
Үндсэн хөрөнгө	1,978,159.1	1,934,573.9	(43,585.2)
Нийт хөрөнгө	2,107,253.6	2,084,962.3	(22,291.3)
Өр төлбөр		450.0	450.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,107,253.6	2,084,512.3	(22,741.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,107,253.6	2,084,962.3	(22,291.3)

Бараа материал дансны үлдэгдэл 21,293.9 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 12,259.2 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, ном үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 108,707.9 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 99,673.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 69,686.1 мянган төгрөгөөр буурсан нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 7,098.8 мянган төгрөгийн ном, 354.0 мянган төгрөгийн ариутгалын материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 26,988.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном, худалдан авсан, сумын ИТХТ-ийн 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 30 дугаар тогтоолоор 50,725.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан, хөрөнгийн үнэлгээг 60,331.2 мянган төгрөгөөр бууруулан бүртгэсэн байна.

Өр төлбөр данс 450.0 мянган төгрөгийн үлдэглтэй тайлагнагдсан нь бараа материалын төлбөрийн өглөгөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,084,512.3 мянган төгрөг болж 22,741.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 10,975.3 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн нь нэмэлт санхүүжилтийн орлого нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,219.0 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн нь цалин,НДШ-ийн зардал, тогтмол зардал өссөн нь голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,659,661.2 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Сургуулийн сургалтын үйл ажиллагаа нь танхим болон

танхимын бус үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,277,542.9** мянган төгрөгийн төсөв баталснаас 1,124,529.0 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 153,013.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,124,529.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 145,107.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд **1,257,769.4** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 11,866.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,257,769.4 мянган төгрөг буюу 99.0 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 9,841.5 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 2,000.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс дээврийн засварт 1,164.0 мянган төгрөг, тусгаарлалтад ажилласан тогооч нарын цалин 1,277.9 мянган төгрөг, БСШУЯ-с *“Бага ангийн сурагчдын хоцрогдол арилгах”* төслийн санхүүжилт 7,590.1 мянган төгрөг, БСУГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 381.0 мянган төгрөг, шалгалтын бичиг хэргийн зардалд 420.0 мянган төгрөгийн санхүүжилт түрээсийн сурах бичгийн үнэ 4,625.4 мянган төгрөг, зэрэг нийт 15,458.4 санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан, түрээсийн номын орлого 4,625.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.”* гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь *“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн*

түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын хоёрдугаар хавсралт “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.7.3 Өндөр настны тэтгэвэр тогтоолгон ажиллаж байгаа багш Д.Санжаад 1,789.1 мянган төгрөгийн ТАХ нэмэгдэл цалин олгосон байна. Уг албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн **36.2.2 дахь заалтын** дагуу өндөр настны тэтгэврээ тогтоолгож, төрийн албанаас бүр мөсөн чөлөөлөгдсөн тул цаашид шаардлагатай гэж үзвэл төрийн албаны шатлалаар бус ажил гүйцэтгүүлэх гэрээний үндсэн дээр төрийн албаны ямар нэгэн нэмэгдэл цалин, урамшуулалгүйгээр ажлын хөлсийг харилцан тохиролцож тогтмолоор тогтоон ажиллах нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 147 мэдээллийг бүрэн оруулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуульд 1,277,542.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,257,769.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.6 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 34,086.8 мянган төгрөгийн шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 78,800.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,976.3 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 886.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 акт тогтоож, 721.9 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 74,215.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд тавилга эд хогшил дансыг 590.8 мянган төгрөгөөр, аж ахуйн материалыг 450.0 мянган төгрөгөөр дутуу, элэгдлийн зардлыг 1,485.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, 450.0 мянган төгрөгийн бараа материалын өглөг тусгаагүй байсныг тус тус залруулав.

4.2 Акт тогтоох

1. Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр Н.Нарантуяа, Т.Тулга, Ж.Сэлэнгэ нарт 258.1 мянган төгрөгийн анги даалт, кабинетын нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал, шийдвэргүйгээр олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас ажилласан цагийн хөлсийг буруу тооцож гурван багшид 331.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүй буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр захирал Б.Эрдэнэ-Очирт 197.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4. “Боловсролын тэргүүний ажилтан” тэмдгээр шагнагдсан багш Ц.Одгэрэлд 100.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид шагнал олгох нийтлэг журмын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь “*Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй.*” гэсэн заалтыг зөрчсөн ба “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр НДШ-ийн шимтгэлийн өглөг гэж тайлант оны батлагдсан төсвөөс 271.9 мянган төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “*Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.3: “*бүх өр төлбөр*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан тооцоог хянан баталгаажуулаагүйгээс бараа материалын төлбөрийн 450.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн

20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 74,215.8 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2. Бараа материалын данстай холбоотой

2.1 Хүнсний материалын худалдан авалтыг 11 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн дээр түүвэрлэж үзэхэд гэрээнд санал болгосон үнийн дүнгээс 8-10 хувиар нэмэгдүүлэн худалдан авалт хийсэн боловч гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-д "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэнд захиалагч дараах тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно", 40.4.1 "хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн, 40.4.2-д "суурь үнэ огцом өөрчлөгдсөн", 41.1.2-д "энэ хуулийн 40.4-д зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэхийг өөрчлөхийг хориглоно" гэж заасны дагуу бараа бүтээгдэхүүний суурь үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3-дахь заалтуудыг зөрчсөн байгаа тул холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль	13	78,800.6	4	2,976.3	4	886.6	2	721.9	3	74,215.8